



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН.**

**Сүхбаатар сум  
2017 оны 4 дүгээр сар**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цэцээн Эрэг II баг  
Утас: 76-36-30-40, Факс: (976) 70-36-30-40  
E-mail: Seienge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ЗАСАГ  
ДАРГА Ш.ОРГИЛ ТАНАА

2017.04.20 № СЭН-2017/01-СТА-783

Тамга № \_\_\_\_\_

**АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ**

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, акрузл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2, 18.2 дахь заалтын дагуу Үндэсний Аудитын газрын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газраас аудит хийв.

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн Аудитын байгууллага нь тус сумын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл:**

Сэлэнгэ аймгийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА